

МОНГОЛ УЛС ДАХЬ ХУВАНЦАР ХОГ ХАЯГДЛЫН ДАХИН БОЛОВСРУУЛАЛТЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨСӨЛ

Европын Холбооны SWITCH Asia II хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжих төсөл



Төслийн хэрэгжүүлэх хугацаа: 2020 оны 5 сарын 1 – 2024 оны 4 сарын 30
Нийт төсөв: 2 сая EUR
Үндсэн хэрэгжүүлэгч: Каритас Чех Републик

Төслийн хамтрагчид: Экосум, Монголын Байгаль Орчин Аюулгүй Байдлын Төв, Т. Г. Масарыкын нэрэмжит Усны Судалгааны Институт, Монголын Тогтвортой Хөгжлийн Гүүр ТББ

ЗОРИЛГО

Монгол улсын эдийн засгийн хөгжил цэцэглэлт, ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулах, ногоон эдийн засгийн хөгжил, нүүрстөрөгч багатай, нөөцийн хэмнэлттэй, тойрог эдийн засагт шилжихэд дэмжлэг үзүүлэх

Төслийн зорилтот байршлууд

Хуванцар хог хаягдлын менежментийн үр дүнтэй тогтолцоог бий болгож, хуванцар дахин боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх

Улаанбаатар

Орон нутгийн дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд туслалцаа үзүүлэх

Булган аймаг

Төслийн үр дүнд Монгол улсад анхны хог хаягдалгүй сум байгуулах

Хишиг-Өндөр сум

Төслийн ашиг шим хүртэгчид



Хуванцар дахин боловсруулах салбарт ЖДҮ эрхлэгчид



Хотын захиргаа, хот-дүүрэг, аймаг, сумын удирдлагууд



Хуванцар хог хаягдал цуглуулах ажилд оролцогчид



Орон нутгийн ТББ-ууд болон иргэний нийгмийн байгууллагууд



Хог хаягдал үүсгэгчид

ХУВАНЦАР ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ, ЯЛГАХ, АНГИЛАХ СИСТЕМИЙГ САЙЖРУУЛАЖ, ТҮҮХИЙ ЭДИЙН НИЙЛҮҮЛЭЛТ ИЛҮҮ ХҮРТЭЭМЖТЭЙ БОЛСОН

- 1 Улаанбаатар хот, Булган аймаг болон Хишиг-Өндөр суманд хуванцар хог хаягдлыг үр ашигтай цуглуулахад тулгарч буй бэрхшээлийг тодорхойлох талбайн судалгаа хийх
- 2 Хот болон хөдөө орон нутагт тохирох хог хаягдлыг цуглуулах, ялгах, ангилах системийг боловсруулах
- 3 Хуванцар хог хаягдлыг ялгах, цуглуулах, ангилах талаар холбогдох төрийн байгууллагуудад сургалт зохион байгуулах
- 4 Хуванцар хог хаягдлыг ялгах, цуглуулах талаарх хэрэглэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой ажиллах нийгэмлэг, иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээг бий болгох
- 5 Хог хаягдлыг цуглуулах, ангилах тухай сургууль, цэцэрлэг, их дээд сургууль болон төрийн байгууллагуудад сурталчилгааны ажлыг зохион байгуулах
- 6 Хуванцар дахин боловсруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх удирдамж, ажлын төлөвлөгөөг санал болгох

ХУВАНЦАР ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРҮҮД ДЭВШИЛТЭТ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ТЕХНОЛОГИЙТ БОЛСОН

- 1 Хуванцар дахин боловсруулах жижиг дунд үйлдвэрүүдийн технологийн цоорхойг тодорхойлж, зохих шинэчлэл, хөрөнгө оруулалтыг санал болгох
- 2 Жижиг дунд үйлдвэрүүдэд санал болгох технологийн шинэчлэл, тэдгээрийн эдийн засгийн үр ашигтай байдлыг танилцуулах семинар зохион байгуулах
- 3 Хуванцар дахин боловсруулах жижиг дунд үйлдвэрүүдэд тулгарч буй санхүүгийн хүртээмжийн дутагдлын талаар судалгаа, дүн шинжилгээ хийх
- 4 Хуванцар дахин боловсруулах жижиг дунд үйлдвэрүүд болон санхүүгийн үйлчилгээ эрхлэгчдийн хоорондын харилцааг сайжруулах
- 5 Хуванцар дахин боловсруулалт хийдэг ЖДҮ-ийн гол ажилчдыг гадаадын ажлын байран дээрх сургалтад хамруулах
- 6 Хуванцар хог хаягдлаар хийсэн шинэ бүтээгдэхүүнийг тодорхойлж, зохион бүтээх
- 7 Сум, аймгийн түвшний оролцогчидтой хамтран хөдөө орон нутагт хуванцар хог хаягдлыг дахин боловсруулах туршилтын ажлуудыг зохион байгуулах

ХУВАНЦАР ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРҮҮДИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО НЬ НЭМЭГДСЭН

- 1 Хуванцар дахин боловсруулах ЖДҮ-үүдийн маркетингийн чадавхыг бий болгох
- 2 Дахин боловсруулсан хуванцараар хийсэн бүтээгдэхүүний эрүүл мэнд, аюулгүй байдал болон чанарын стандартуудыг боловсруулах
- 3 Дахин боловсруулах бүтээгдэхүүнийг сурталчлах сургалт семинар болон үзэсгэлэн зохион байгуулах
- 4 ЖДҮ-ийн төлөөлөгчдөд дахин боловсруулсан бүтээгдэхүүн сурталчлах, борлуулах талаар гадаадад туршлага судлах аялал зохион байгуулах
- 5 Дахин боловсруулсан хуванцраар хийсэн бүтээгдэхүүний зах зээлийн боломжийг судлах

ТӨСЛИЙГ БУСАД АЙМАГ, СУМДАД ХЭРЭГЖҮҮЛЭХэд ТҮЛЭЭЦ БОЛСОН

- 1 Төслөөс гарсан үр дүнг бусад аймгуудад түгээн дэлгэрүүлэн нэвтрүүлэхэд түлээц үзүүлэх шийдвэр гаргагчидтай уулзалт, зөвлөгөөн зохион байгуулах
- 2 Төслийн үр дүнг түгээн дэлгэрүүлэхэд орон нутгийн болон олон улсын хог хаягдлын менежментийн чиглэлийн экспертүүдээс бүрдсэн кластерыг байгуулах
- 3 Төслийн үр дүнд гарсан ололт, зөвлөмж, шийдэл, шилдэг туршлагыг агуулсан багц мэдээллийг боловсруулж түгээх

Хаяг: 503тоот, 5 давхар, Делта төв, 1-р хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот

Утас: +976 70135899

Цахим шуудан: ccr.mongolia.office@caritas.cz

Вэбсайт: <https://mongolia.charita.cz/>

Facebook: Caritas Czech Republic in Mongolia

Тодорхой зорилтууд

- ЖДҮ-үүд тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэлийн (ТХУ) практик арга барилыг нэвтрүүлэхийг дэмжиж, ТХУ-ийн загварыг сурталчлах
- Үндэсний ТХУ-ийн бодлогын хэрэгжилтийг бэхжүүлж, ТХУ-ийн үр ашгийг хүртэхэд оролцогч талуудад туслалцаа таатай орчинг бүрдүүлэх